



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 11 сарын 25-ны
өдрийн 5562 дугаарт бүртгэв.

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хэмжил зүйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, Стандарт, хэмжил зүйн газрын даргын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн хянуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх зохих арга хэмжээ авч ажиллахыг Хэмжил зүйн бодлогын газар (Д.Нарангэрэл)-т, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Ууганбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

ДАРГА


Б.БИЛГҮҮН



Бүртгэлийн дугаар 93
ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
тохируулагч агентлаг
СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын эрхлэгч
2021 оны 11 сарын 08 өдөр

02002-041

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2021 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн
А/155 дугаар тушаалын хавсралт



ХЭМЖИЛ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Хэмжил зүйн тухай хуулийн 21 дүгээр зүйл, 19 дүгээр зүйлийн 19.2.4-т заасныг үндэслэн тодорхой салбарт хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагад тавих шаардлагыг тогтоох, түүний чадавхыг үнэлэх, эрх олгох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Хэмжил зүйн төв байгууллага” гэх) хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлэх, эрх олгох үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулна.
- 1.3 Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн эрэлт, хэрэгцээ, шаардлагыг гол үндэслэл болгон холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухайн салбарын хүрээний төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдэд хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх олгоно.
- 1.4 Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлэхтэй холбогдон гарах ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг Хэмжил зүйн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т зааснаар хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хоёр. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага

- 2.1 Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь Хэмжил зүйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1-т заасан хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1 Хэмжил зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан жагсаалтад орсон хэмжих хэрэгсэлд загварын туршилт, шалгалт баталгаажуулалт хийх;
 - 2.1.2 Тухайн эрх авах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай байх;
 - 2.1.3 Зөвхөн эрх олгогдсон хамрах хүрээнд үйл ажиллагаа эрхлэх;
 - 2.1.4 Ажлын эталоныг бий болгох, сайжруулах, нэгж дамжуулалтыг хангасан байх;
 - 2.1.5 Лаборатори нь холбогдох стандартад заасан шаардлагыг бүрэн хангасан байх;

Бүртгэлийн дугаар 93

ХУУЛБАР ҮНЭН
Монгол улсын Засгийн газрын
тожруулагч агентлаг
СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Архивын эрхлэгч
Ф. В. Д.
2021 оны 11 сарын 08-ний өдөр

2.1.6 Тухайн хэмжлийн төрлөөр загварын туршилт гүйцэтгэх ажилтан нь хэмжил зүйн холбогдох сургалтад хамрагдаж, мэргэшсэн байх, шалгалт баталгаажуулалт гүйцэтгэх ажилтан нь улсын шалгагчийн эрх авсан байх;

2.1.7 Хэмжил зүйн үйл ажиллагаандаа холбогдох стандарт, техникийн баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулж, бүрдүүлсэн байх;

2.2 Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь Хэмжил зүйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2-т заасан хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1 Хэмжил зүйн төв байгууллагаас нэгж дамжуулах боломжгүй байгаа тухайн хэмжлийн төрлөөр бий болгосон эсхүл шинээр бий болгох улсын эталон нь олон улсын SI системийн хэмжлийн нэгж дамжуулалтыг хангасан байх;

2.2.2 Тухайн хэмжлийн төрлөөр улсын эталон хадгалах ажилтан нь хэмжил зүйн холбогдох сургалтад хамрагдаж, мэргэшсэн байх, шалгалт тохируулгын ажилтан нь холбогдох журмын дагуу чадавхаа үнэлүүлсэн байх;

2.2.3 Хэмжил зүйн үйл ажиллагаандаа холбогдох стандарт, техникийн баримт бичиг, арга, аргачлалыг боловсруулж, бүрдүүлсэн байх;

2.2.4 Хэмжлийн эталоныг хадгалах, ашиглах, нэгж дамжуулалтыг хангах стандартын шаардлагад нийцсэн лаборатори, ажлын байртай байх;

2.2.5 Тухайн хэмжлийн төрөл, хамрах хүрээнд шалгалт тохируулгаар дамжуулан нэгж дамжуулалтыг хангах;

2.2.6 ISO/IEC 17025 менежментийн тогтолцоог нэвтрүүлж, итгэмжлэгдсэн байх;

2.2.7 Стандартчилсан загвар зохион бүтээх бол ISO 17034 менежментийн тогтолцоог нэвтрүүлж, итгэмжлэгдсэн байх;

2.2.8 Эталоныг бий болгох, хөгжүүлэх, олон улсын нэгж дамжуулалт хангах санхүүгийн нөөцтэй байх.

2.3 Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага энэ журмын 2.1, 2.2-т заасан шаардлагыг хангаж, чадавхаа үнэлүүлсэн тохиолдолд Хэмжил зүйн тухай хуулийн 21.1.1, 21.1.2-т заасан чиг үүргийг давхар эрхэлж болно.

Гурав. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлэх, эрх олгох

3.1 Энэ журмын 2-т заасан шаардлага хангасан байгууллага нь журмын нэгдүгээр хавсралтын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар ажиллах, чадавхаа үнэлүүлэх хүсэлтээ Хэмжил зүйн төв байгууллагад ирүүлнэ.

Бүртгэлийн дугаар	93
Хэмжил зүйн газар	
Архивын эрхлэгч	<i>S. Y. A.</i>
20 21 оны 11 сарын 08	ний өдөр

3.2 Хэмжил зүйн төв байгууллагын даргын шийдвэрээр хүсэлт гаргасан хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чадавхыг тогтоох үнэлгээний ажлын хэсэг томилох бөгөөд ажлын хэсгийн гишүүн нь хэмжил зүйн холбогдох сургалтад хамрагдсан, хэмжил зүйн болон тухайн хэмжлийн төрлөөр 3-аас доошгүй жил ажилласан, ур чадвар, туршлагатай байна.

3.3 Үнэлгээний ажлын хэсэг ирүүлсэн баримт бичигт үзлэг хийж энэ журмын 2.1 эсхүл 2.2-т заасан шаардлага хангаж байгаа эсэхэд газар дээрх үнэлгээг явуулж, 30 хоногт багтаан дүгнэлт гаргана.

3.4 Ажлын хэсгийн үнэлгээ, дүгнэлтээр энэ журамд заасан шалгуур үзүүлэлт, шаардлага хангасан тохиолдолд Хэмжил зүйн Зөвлөлийн хуралдаанд танилцуулан, тэмдэглэлийг үндэслэн Хэмжил зүйн төв байгууллагын даргын шийдвэрээр хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу тухайн хэмжлийн төрлөөр тодорхой заасан хамрах хүрээнд эрх олгож, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.

3.5 Энэ журамд заасан шаардлага хангаагүй эсхүл хүсэлт гаргасан төрлөөр улсын эталоныг хадгалах, нэгж дамжуулах, шалгалт тохируулга, баталгаажуулалт, загварын туршилт хийх эталоны болон хүний нөөц хангалтгүй гэж ажлын хэсгийн үнэлгээ, дүгнэлт гарсан бол хэмжил зүйн төв байгууллага дүгнэлтийг тухайн байгууллагад албан бичгээр энэ журмын 3.3-т заасан хугацаанд мэдэгдэнэ.

3.6 Хэмжил зүйн төв байгууллагаас чадавхаа үнэлүүлсэн байгууллагын үйл ажиллагаанд хоёр жил тутам газар дээрх хяналтын магадлан үнэлгээг хийх ба иргэд, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн гомдол, хүсэлтийг үндэслэн үзлэг шалгалтыг хийж болно. Магадлан үнэлгээ, шалгалтын дүгнэлт тайланг Хэмжил зүйн Зөвлөлийн хуралдаанаар тайлагнаж хэлэлцүүлнэ.


Дөрөв. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг

4.1 Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага Хэмжил зүйн төв байгууллагатай эрх олгогдсон чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг ханган ажиллана.

4.2 Хэмжил зүйн үйл ажиллагаа, менежментийн тогтолцоо ба нөөцөд өөрчлөлт орсон бол Хэмжил зүйн төв байгууллагад мэдэгдэнэ.

4.3 Хэмжил зүйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1-т заасан хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх бол дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.3.1 Чадавхаа үнэлүүлсэн тухайн хамрах хүрээнд хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт болон Хэмжил зүйн төв байгууллагаас баталсан "Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журам", "Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх журам"-ыг мөрдөж ажиллах;



4.3.2 Шалгалт баталгаажуулалт, загварын туршилт хийгдсэн хэмжих хэрэгслийн тоо, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэмжил зүйн төв байгууллагад хагас жил тутам ирүүлж хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлэх;

4.3.3 Хэмжил зүйн төв байгууллагын санал болгосноор хууль эрхийн хэмжил зүйн олон улсын холбогдох байгууллагын шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.

4.4 Хэмжил зүйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2-т заасан хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх бол дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.4.1 Чадавхаа үнэлүүлсэн тухайн хамрах хүрээний улсын эталоныг Засгийн газраар батлуулах, хөтлөх, нэгж дамжуулалтыг хангах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг мөрдөж ажиллах;

4.4.2 Улсын эталоныг бий болгож, хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажил явуулах;

4.4.3 Үндэсний болон олон улсын харьцуулалт эсхүл ур чадварын сорилтод оролцох, зохион байгуулах;

4.4.4 Хэмжил зүйн төв байгууллагын санал болгосноор дараах шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд хэмжил зүйн олон улсын холбогдох байгууллагад ажиглагч гишүүнээр элсэж, албан ёсоор бүртгүүлж болох бөгөөд түүний үйл ажиллагаанд идэвхтэй оролцох. Үүнд:

4.4.4.1 Таваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн, холбогдох стандартад заасан хангалттай нөөцтэй байх;

4.4.4.2 Эталоны нэгж дамжуулалтыг тогтмол хангадаг байх;

4.4.4.3 Хэмжил зүйн олон улсын байгууллагаас тавих тусгай шаардлагуудыг ханган ажиллах;

4.4.4.4 Олон улсын түвшинд ажиллах чадавхтай байх.


4.4.5 Хэмжил, шалгалт тохируулгын чадавхыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх;

4.5 Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, загварын туршилт, шалгалт баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэхдээ хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан төлбөрийн хэмжээг мөрдөнө.

Тав. Бусад

5.1 Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----




Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын
чадавхыг үнэлэх журмын нэгдүгээр хавсралт

Чадавхаа үнэлүүлэх хүсэлт ирүүлэхэд бүрдүүлэх
материалын жагсаалт

Хүсэлт гаргасан байгууллагын нэр:

Огноо:

№	Агуулга	Шаардлагын дагуу баримт бичгийг хавсаргасан эсэх
1	Албан бичгээр ирүүлсэн хүсэлт	
2	Байгууллагын танилцуулга /хэмжил зүйн үйл ажиллагаа/	
3	Төрийн захиргааны төв байгууллагаас тухайн салбарт хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаар ажиллуулах санал /Тухайн салбарын асуудал эрхэлсэн сайдын гарын үсэгтэй албан бичиг/	
4	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, ажилтнуудын үүрэг хариуцлага, чадавхыг тодорхойлсон баримт бичиг, түүний хуулбар	
5	Ашиглаж байгаа эталон, стандартчилсан загвар, тоног төхөөрөмжийн жагсаалт, нэгж дамжуулалтын бүдүүвч, мэдээлэл	
6	Холбогдох стандарт, баримт бичиг, дүрэм, журам, зааврын жагсаалт, хуулбар	
7	Ажлын байр, лабораторийн орчин, нөхцлийн талаарх мэдээлэл	
8	ISO/IEC 17025 (стандартчилсан загвар зохион бүтээх бол ISO 17034) менежментийн тогтолцоог нэвтрүүлж, итгэмжлэгдсэн хамрах хүрээ болон гэрчилгээний хуулбар	
9	Хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээ	



Хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын
чадавхыг үнэлэх журмын хоёрдугаар хавсралт

/ / хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын нэр/-ийн
..... салбарын хүрээнд
хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэх хамрах хүрээ

№	Хэмжил зүйн үзүүлэлт			Үйл ажиллагааны төрөл		
	Хэмжлийн төрөл	Хэмжих хязгаар	Анги нарийвчлал эсхүл хэмжлийн эргэлзээ	Улсын эталон бий болгох, нэгж дамжуулалт хангах	Хэмжих хэрэгслийн загвары туршилт хийх	Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт
1.						
2.						
3.						
4.						

